

Цөмийн болон цацрагийн хяналтын хэлтэс
2025 ОНЫ ЖИЛИЙН ЭЦЭС-Н ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

№	Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төсөв	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин		Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/	Гүйцэтгэл-ийн хувь	
					Эхний хагас жил	Сүүлийн хагас жил		Өөрийн үнэлгээ	ХШҮ
Гурав. Хуулиар тусгайлан олгосон чиг үүргийг хэрэгжүүлэх зорилт, арга хэмжээ									
3.1.	Цөмийн болон цацрагийн хяналтын чиглэлээр төлөвлөгөөт, урьдчилан сэргийлэх хяналт шалгалтыг хэрэгжүүлнэ.	Үйл ажиллагааны зардлаар	Хяналт шалгалтад хамрагдсан объектын гүйцэтгэлийн хувь	75	100	Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Цөмийн болон цацрагийн хяналтын салбарын улсын ерөнхий байцаагчийн баталсан 06-00/012, 06-00/013 тоот 2 удирдамжийн хүрээнд Төлөвлөгөөт хяналт шалгалтыг, 06-00/005,06-00/006, 06-00/007, 06-00/008, 06-00/009, 06-00/010 тоот 6 удирдамжийн хүрээнд Урьдчилан сэргийлэх хяналт шалгалтыг тус тус хэрэгжүүллээ. 1.Төлөвлөгөөт хяналт шалгалтын 2 удирдамжийн хүрээнд шалгалтад нийт 60 аж ахуй нэгж байгууллагыг хамруулж, 680 зөрчил	100%	95%	

					<p>илрүүлж,10 цацрагийн үүсгүүр, рентген аппаратын ашиглалтыг түр зогсоож, зөрчил дутагдлыг арилгуулахаар 402 заалттай улсын байцаагчийн 55 албан шаардлага, ноцтой зөрчил гаргасан 3 хуулийн этгээдэд зөрчлийн хэрэг нээж, 9 сая төгрөгийн шийтгэл оногдуулж, хугацаанд нь барагдуулан эрх бүхий албан тушаалтны 3 албан даалгавар хүргүүлж, хэрэгжилтэд нь хяналт ажилласан. 2. Урьдчилан сэргийлэх хяналт шалгалтын 6 удирдамжийн хүрээнд: - Мэргэжлийн шарлагын хяналтад 430 байгууллагын 1673 цацрагтай ажиллагчийг хамруулж - Тусгай зөвшөөрөлгүй цацрагийн үүсгүүрийг 19 бууруулсан - Улаанбаатар хотын төвлөрсөн усан хангамжийн 9 эх үүсвэр, Дорнод аймгийн Дорнод нийтийн аж ахуй ОНӨААТУГ-аас ундны усны нийт 60 дээж - ХАБҮЛЛ-ийн Цацрагийн хяналтын лаборатори, Улсын мал эмнэлэг ариун цэврийн төв</p>		
--	--	--	--	--	--	--	--

							<p>лабораториудад 2025 онд импортын хүнсний бүтээгдэхүүний 7 нэр төрлийн 374 дээж -Дорнод бүсийн эрчим хүчний систем ТӨХК, Дулааны цахилгаан станц (ДЦС) – ууд II, III, IV, Амгалан дулааны станц, Сэлбэ дулааны станцын зуухны үнс, хаягдал үнсэн сангийн үнснээс 17 дээж, үнсэн сан орчмын хөрсний 3 дээж нийт 20 дээж - Геологи хайгуулын чиглэлээр цацрагийн үүсгүүр хадгалах байргүй ч цацраг идэвхт үүсгүүр ашиглаж буй 7 аж ахуйн нэгжийн нийт 8 цацраг идэвхт үүсгүүрийг хадгалалтад шилжүүлэхэд хяналт тавьж, Нийслэлд цацраг идэвхт үүсгүүр хадгалах байртай 8 аж ахуйн нэгжээс цацраг идэвхт үүсгүүрийг хөдөө орон нутагт тээвэрлэх, шилжилт хөдөлгөөн хийсэн талаарх нийт 53 мэдэгдлийг хүлээн авч, урьдчилан сэргийлэх хяналт шалгалтыг хэрэгжүүлсэн.</p>		
3.1.1	Рентген оношилгооны чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй их, дунд эрсдэлтэй	Үйл ажиллагааны зардлаар	Хууль сахин мөрдөлтийн хувь (өссөн дүнгээр)	80	81	82	Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Цөмийн болон цацрагийн хяналтын салбарын улсын	93%	90%

	<p>үнэлэгдсэн нийт 45 аж ахуйн нэгж, байгууллагад төлөвлөгөөт хяналт шалгалт хийх</p>				<p>ерөнхий байцаагчийн баталсан 06-00/013 удирдамжийн хүрээнд төлөвлөгөөт хяналт шалгалтад хамрагдах 45 ААНБ-уудад хяналт шалгалт хийх тухай мэдэгдэх хуудсыг бичиж, хяналт шалгалтын удирдамжийн хамт хүргүүлсэн. Удирдамжийн дагуу рентген оношилгооны чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй 45 байгууллагад төлөвлөгөөт хяналт шалгалт хийж, рентген аппаратын цацрагийн аюулгүй ажиллагааг 6.18 кодтой “Рентген оношилгооны цацрагийн аюулгүй ажиллагааг шалгах хяналтын хуудас”-аар шалгахад нийт 505 зөрчил, дутагдал илэрч, бага эрсдэлтэй 25, дунд эрсдэлтэй 15, их эрсдэлтэй 3, үйл ажиллагаа зогссон 2 аж ахуйн нэгж үнэлэгдэж, хууль сахин мөрдөлтийн хувь 77 байна. Хяналт шалгалтаар илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулахаар 301 заалттай улсын байцаагчийн 41 албан шаардлагыг хүргүүлж, Зөрчлийн тухай хуулийн</p>		
--	---	--	--	--	---	--	--

							тусгай ангийн 12.11 зүйлд заасан зөрчил гаргасан 2 аж ахуйн нэгж байгууллагад зөрчлийн хэрэг нээж, зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа явуулан, прокурорын тогтоолоор 8 рентген аппаратын ашиглалтыг зөрчил арилтал түр зогсоож, зөрчлийг арилгуулахаар эрх бүхий албан тушаалтны 16 заалттай 2 албан даалгавар хүргүүлэн, 6 сая төгрөгийн шийтгэж оногдуулж, хугацаанд нь бүрэн барагдуулан биелэлтэд хяналт тавьж ажилласан. Мөн хяналт шалгалтад хамрагдсан ААНБ-ын хяналт шалгалтын мэдээллийг шилэн хяналтын системд бүрэн оруулж цахим мэдээллийн санг бүрдүүлсэн.		
3.1.2	Цацрагийн үүсгүүр ашиглаж, хадгалж буй 15 аж ахуйн нэгж, байгууллагад төлөвлөгөөт хяналт шалгалт хийх	Үйл ажиллагааны зардлаар	Хууль сахин мөрдөлтийн хувь (өссөн дүнгээр)	75	76	77	Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Цөмийн болон цацрагийн хяналтын салбарын улсын ерөнхий байцаагчийн баталсан 06-00/012 удирдамжийн хүрээнд төлөвлөгөөт хяналт шалгалтад хамрагдах 15 ААНБ-уудад хяналт шалгалт хийх тухай	94%	90%

						<p>мэдэгдэх хуудсыг бичиж, хяналт шалгалтын удирдамжийн хамт хүргүүлсэн. Удирдамжийн дагуу цацрагийн үүсгүүр ашиглаж, хадгалж буй 15 ААНБ-уудад төлөвлөгөөт хяналт шалгалт хийж, рентген тоног төхөөрөмжүүдийн цацрагийн аюулгүй ажиллагааг 06.17 кодтой Цацрагийн үүсгүүрийн аюулгүй ажиллагааг шалгах хяналтын хуудас, 6.19 кодтой “Рентген багаж, тоног төхөөрөмжийн цацрагийн аюулгүй ажиллагааг шалгах хяналтын хуудас”-аар шалгахад давхардсан тоогоор нийт 101 зөрчил, дутагдал илэрч, их эрсдэлтэй 4, дунд эрсдэлтэй 6, бага эрсдэлтэй 5 ААНБ үнэлэгдэж, хууль сахин мөрдөлтийн дундаж хувь 73 байна. Хяналт шалгалтаар илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулахаар давхардсан тоогоор нийт 101 заалттай улсын байцаагчийн 14 албан шаардлага хүргүүлж, Зөрчлийн тухай хуулийн тусгай ангийн 12.11 зүйлд заасан зөрчил гаргасан 1</p>	
--	--	--	--	--	--	--	--

							аж ахуйн нэгж байгууллагад зөрчлийн хэрэг нээж, зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа явуулан, прокурорын тогтоолоор 3 цацрагийн үүсгүүрийн ашиглалтыг зөрчил арилтал түр зогсоож, зөрчлийг арилгуулахаар эрх бүхий албан тушаалтны 14 заалттай 1 албан даалгавар хүргүүлэн, 3 сая төгрөгийн шийтгэж оногдуулж, хугацаанд нь бүрэн барагдуулан биелэлтэд хяналт тавьж ажилласан. Мөн хяналт шалгалтад хамрагдсан ААНБ-ын хяналт шалгалтын мэдээллийг шилэн хяналтын системд бүрэн оруулж цахим мэдээллийн санг бүрдүүлсэн.		
3.1.3	Төлөвлөгөөт хяналт шалгалтад хамрагдсан нийт 60 аж ахуйн нэгж, байгууллагад гүйцэтгэлийн хяналт шалгалт хийх	Үйл ажиллагааны зардлаар	Албан шаардлагын заалтын биелэлтийн хувь	85.5	85.7	86	Төлөвлөгөөт шалгалтаар улсын байцаагчийн албан шаардлага, эрх бүхий албан тушаалтны албан даалгавраар хугацаатай өгсөн үүрэг даалгаврын биелэлтийг ирүүлсэн 37 аж ахуйн нэгж, байгууллагад гүйцэтгэлийн хяналт шалгалтыг хийж, хяналтын хуудсаар илэрсэн нийт 456	100%	100%

							<p>зөрчлөөс 396 зөрчлийг бүрэн арилгуулж, 86.8 хувиар зөрчлийг бууруулсан. Зөрчлийн тухай хуулийн холбогдох заалтыг зөрчсөн 3 аж ахуйн нэгж байгууллагад өгсөн эрх бүхий албан тушаалтны 30 заалттай 3 албан даалгавраас 26 заалт бүрэн биелж, албан даалгаврын биелэлт 86.5 хувь, 3 хуулийн этгээдэд ноогдуулсан 9 сая төгрөгийн шийтгэлийг хугацаанд нь бүрэн барагдуулсан.</p> <p>Төлөвлөгөөт шалгалтаар илэрсэн зөрчлийг арилгуулахаар өгсөн улсын байцаагчийн нийт 314 заалттай 34 албан шаардлагаас 270 заалт бүрэн биелж, албан шаардлагын заалтын биелэлт 86 хувьтай байна.</p>		
3.1.4	Цацрагийн үүсгүүрийн шилжилт хөдөлгөөн, тээвэрлэлтийн аюулгүй байдалд урьдчилан сэргийлэх шалгалт хийх	Үйл ажиллагааны зардлаар	Хяналт шалгалтад хамрагдсан объектын тоо	-	5	10	<p>АҮЭБЯ-ны Цөмийн болон цацрагийн улсын ерөнхий байцаагчийн 2025 оны 01 дүгээр сарын 29-ний өдөр баталсан 06-00/009 тоот удирдамжийн дагуу өөрийн хадгалах байргүй ч цацраг идэвхт үүсгүүр ашиглаж буй 7 аж ахуйн нэгжийн нийт 8 цацраг идэвхт үүсгүүрийг Цөмийн энергийн комиссын Ажлын</p>	100%	100%

							албаны Изотоп конторын хадгалалтаас ашиглалтад шилжүүлэн өгөх үйл ажиллагаанд урьдчилан сэргийлэх хяналт тавьж, цацраг идэвхт үүсгүүрийн тээвэрлэлтийн аюулгүй байдлыг хангуулан ажилласан. Нийслэлд цацраг идэвхт үүсгүүр хадгалах байртай 8 аж ахуйн нэгжээс цацраг идэвхт үүсгүүрийг хөдөө орон нутагт тээвэрлэх, шилжилт хөдөлгөөн хийсэн талаарх нийт 53 мэдэгдлийг хүлээн авч, шилжилт хөдөлгөөнийг бүртгэн, мэдээллийн сан бүрдүүлсэн. Цагаан сарын бүх нийтийн баяр ёслолын өдрүүдэд, Үндэсний их баяр наадам, бүх нийтээр амрах өдрүүдэд цацраг идэвхт үүсгүүр хэрэглэгч 17 аж ахуйн нэгж байгууллагуудад цацрагийн болзошгүй ослоос урьдчилан сэргийлэх тухай мэдэгдлийг боловсруулж, 1/1059, 1/3349 дугаартай албан бичгээр тус тус хүргүүлсэн.		
3.1.5	Тусгай зөвшөөрөлгүй цацрагийн үүсгүүрийг илрүүлэх урьдчилан сэргийлэх шалгалт	Үйл ажиллагааны зардлаар	Тусгай зөвшөөрөлгүй цацрагийн үүсгүүрийг	17	18	20	АҮЭБЯ-ны Цөмийн болон цацрагийн хяналтын улсын ерөнхий байцаагчийн баталсан 06-	95%	90%

	хийх		бууруулсан тоо			<p>00/007 дугаартай “Урьдчилан сэргийлэх шалгалт хийх тухай” удирдамжийн хүрээнд 7 аж ахуйн нэгж байгууллагад урьдчилан сэргийлэх хяналтыг хийж, цацрагийн үүсгүүр ашиглах хадгалах эрхийн тусгай зөвшөөрөлгүй ашиглаж, хадгалж байсан 19 ширхэг рентген аппарат, цацрагийн үүсгүүрийг илрүүлсэн. Хяналтаар тусгай зөвшөөрөл авах хүсэлт гаргасан нийт 4 байгууллагын 5 цацрагийн үүсгүүр рентген төхөөрөмжийн ашиглалтын үйл ажиллагааг тусгай зөвшөөрөл авах хүртэл улсын байцаагчийн актаар түр зогсоосон. Цацрагийн үүсгүүр ашиглах, хадгалах эрхийн тусгай зөвшөөрөлгүйгээр үйл ажиллагаа явуулж байсан 2 байгууллагад зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа явуулан, рентген аппаратын ашиглалтын үйл ажиллагааг эрх бүхий албан тушаалтны тогтоолоор зөрчил арилтал түр зогсоож, 6 сая төгрөгийн торгох</p>		
--	------	--	----------------	--	--	---	--	--

							шийтгэл оногдуулж, хугацаанд нь барагдуулж, Цөмийн энергийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.3 дахь заалтын хэрэгжилтийг хангуулан ажилласан.		
3.1.6	Цацрагтай ажиллагчдын мэргэжлийн шарлагын хувийн тунд урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийх	Үйл ажиллагааны зардлаар	1.Хяналтад хамрагдсан байгууллагын тоо (өссөн дүнгээр) 2. Цацрагтай ажиллагчдын тоо (өссөн дүнгээр)	1.419 2.1673	1.420 2.1675	1.425 2.1680	АҮЭБЯ-ны Цөмийн болон цацрагийн хяналтын Улсын ерөнхий байцаагчийн 2025 оны 01 дүгээр сарын 29-ний өдөр баталсан 06-00/010 дугаартай урьдчилан сэргийлэх удирдамжийн дагуу Стандарт, хэмжил зүйн газрын Хүнсний аюулгүй байдлын үндэсний лавлагаа лабораторийн Цацрагийн хяналтын лабораторид хэмжсэн 430 аж ахуйн нэгж, байгууллагын 1728 цацрагтай ажиллагчдын мэргэжлийн шарлагын хувийн тунд хяналт тавьж ажилласан. Цацрагтай ажиллагчдын сард авч болох дундаж хэмжээнээс их гарсан 8 аж ахуйн нэгж, байгууллагын 10 тохиолдол илэрснийг шалтгаан нөхцөлийг тодруулах албан бичиг хүргүүлэн, цацрагтай ажиллагчдын ажлын ачаалал, хийж хэрэгжүүлсэн ажлын	100%	100%

						<p>тайланг хариу албан бичгээр авч, тунд үнэлгээ хийж ажилласан. Цацрагтай ажиллагчдын жилд авч болох дундаж хэмжээнээс өндөр гарсан Цагаан хясаа ХХК, Дархандетект ХХК-ийн эмнэлгийн цацрагтай ажиллагчдын 5 нэмэгдэл шарлага илэрсэн шалтгаан нөхцөлийг тогтоох зорилгоор урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийж, цацрагтай ажиллагчдын нэмэгдэл шарлага авсан болон сарын дундаж хэмжээнээс хэтэрсэн шалтгаан нөхцөлийг тогтоох үнэлгээний хуудсаар үнэлж, цацрагтай ажиллагчийн ажлын байранд цацрагийн эрүүл ахуйн дозиметрийн хяналт хийж, Стандарт хэмжил зүйн газрын ХАБҮЛЛ-ийн Цацрагийн хяналтын итгэмжлэгдсэн лабораторийн ТЛД25-1063, ТЛД25-1064 шинжилгээний дүнг үндэслэн Цагаан хясаа шүдний эмнэлгийн цацрагтай ажиллагч П.Үүрийнцолмонгийн дозиметрийн хэмжилтийн дүн нь ажил мэргэжлээсээ аваагүй болохыг, Сүүл</p>	
--	--	--	--	--	--	--	--

							мед эмнэлгийн цацрагтай ажиллагч А.Айнурын хувийн дозиметрийн хэмжилтийн дүн нь ажил үүргээ гүйцэтгэхдээ авсан мэргэжлийн шарлага болохыг тус тус тогтоож улсын байцаагчийн нийт 4 заалттай 06/13-06/043/01, 06/13-06/043/02 тоот дүгнэлт хүргүүлсэн. Шалгалтаар илэрсэн алдаа дутагдлыг арилгуулахаар тус 2 байгууллагад нийт 12 заалт бүхий улсын байцаагчийн 06/13-06/043/01, 06/13-06/043/02 тоот албан шаардлага хүргүүлж хэрэгжилтэд хяналт тавьж ажилласан. Хяналт шалгалтын танилцуулгыг нэгтгэж, АҮЭБЯ-д 1/5972 тоот бичгээр хүргүүлсэн.		
3.1.7	Төвлөрсөн усан хангамжийн эх үүсвэр, ундны усанд урьдчилан сэргийлэх шалгалт хийх	Үйл ажиллагааны зардлаар	1.Шинжилгээнд хамрагдсан эх үүсвэрийн тоо (өссөн дүнгээр) 2.Шинжилгээнд хамруулсан дээжний тоо (өссөн дүнгээр)	1.9 2.28	1.7 2.20	1.10 2.30	Аж үйлдвэр эрдэс баялгийн яамны Цөмийн болон цацрагийн хяналтын салбарын улсын ерөнхий байцаагчийн баталсан 06-00/008 удирдамжийн хүрээнд Улаанбаатар хотын төвлөрсөн усан хангамжийн 9 эх үүсвэрээс ундны усны 58 дээж, Дорнод аймгийн Дорнод нийтийн аж ахуй	100%	100%

							ОНӨААТУГ-аас ундны усны 2 дээж тус тус авч нийт ундны усны 60 дээж авч, Стандарт хэмжил зүйн газрын Хүнсний аюулгүй байдлын үндэсний лавлагаа лабораторийн Цацрагийн хяналтын лабораторид цацрагийн шинжилгээнд хамруулж урьдчилан сэргийлэх шалгалт хийсэн.		
3.1.8	Импортын хүнсний бүтээгдэхүүнийг цацрагийн шинжилгээнд хамруулах урьдчилан сэргийлэх шалгалтыг төрийн байгууллагатай хамтран хийх	Үйл ажиллагааны зардлаар	Мэргэжил арга зүйгээр хангасан байгууллагын тоо	-	-	2	Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Цөмийн болон цацрагийн хяналтын салбарын улсын ерөнхий байцаагчийн баталсан импортын хүнсний бүтээгдэхүүнийг цацрагийн шинжилгээнд хамруулах урьдчилан сэргийлэх шалгалт хийх тухай 06-00/010 дугаартай удирдамжийн хүрээнд Хүнсний аюулгүй байдал, үндэсний лавлагаа лабораторийн Цацрагийн хяналтын лаборатори, Улсын мал эмнэлэг ариун цэврийн төв лабораториудад 2025 онд импортын хүнсний бүтээгдэхүүний дээжинд цацрагийн шинжилгээ хийсэн дүнг ирүүлэх тухай 1/2053, 1/2055, 1/2056 тоот албан бичгүүдийг тус тус хүргүүлж, мэргэжил	100%	100%

							арга зүйгээр хангаж, ажилласан. Удирдамжийн хүрээнд дээрх 2 лабораторид 7 нэр төрлийн 374 дээжийг цацраг идэвхт изотопуудын хувийн идэвх тодорхойлох шинжилгээнд хамруулсан шинжилгээний дүнгээс үзэхэд Цези-137, Кали-40 изотопуудын үзүүлэлт Монгол Улсад мөрдөгдөж буй "Цацрагийн аюулгүйн норм"-ын шаардлагыг хангаж байна.		
3.1.9	Дулааны цахилгаан станц, нам даралтын зуухнаас гарч буй хаягдал үндсэнд цацрагийн эх үүсгүүр байгаа эсэхэд шинжилгээт урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийх	Үйл ажиллагааны зардлаар	Шинжилгээнд хамруулсан дээжний тоо (өссөн дүнгээр)	13	15	17	АҮЭБЯ-ны Цөмийн болон цацрагийн хяналтын Салбарын улсын ерөнхий байцаагчийн 2025 оны 01 дүгээр сарын 24-ны өдөр баталсан Урьдчилан сэргийлэх шалгалт хийх тухай 06-00/005 тоот удирдамжийн хүрээнд Дорнод бүсийн эрчим хүчний систем ТӨХК, Дулааны цахилгаан станц (ДЦС) –ууд II, III, IV, Амгалан дулааны станц, Сэлбэ дулааны станцын зуухны үнс, хаягдал үнсэн сангийн үнснээс 17 дээж, үнсэн сан орчмын хөрсний 3 дээж нийт 20 дээж авч, СХЗГ-ын Хүнсний аюулгүй байдлын үндэсний лавлагаа лабораторийн	100%	100%

						Цацрагийн хяналтын лабораторийн цацрагийн шинжилгээнд хамруулсан. ЦХЛ-ийн шинжилгээний дүнгээс үзэхэд хөрсний 3 дээжид зохиомол цацраг идэвхт цези-137 изотоп илрээгүй ба хаягдал үнсний 17 дээжид К-40 изотоп 184-883 Бк/кг, Ra-226 изотоп 118-424 Бк/кг, Th-232 изотоп 39-115 Бк/кг, Радийн эквивалент 196-593 Бк/кг байгаа нь Цацрагийн аюулгүйн нормын шаардлагыг хангаж байна.			
Гурав. Хуулиар олгосон нийтлэг чиг үүргийг хэрэгжүүлэх зорилт, арга хэмжээ									
4.1.	Салбарын чиглэлээр мөрдөгдөж буй хууль бусад хууль тогтоомжийн төсөлд санал өгөх, төслийн хувилбар боловсруулна	Үйл ажиллагааны зардлаар	Хууль, журамд нийцүүлэн гүйцэтгэсэн ажлын хувиар	-	100	Газрын даргын 2025 оны 01 дүгээр сарын 02-ны өдрийн “Ажлын хэсэг байгуулах” тушаалын хүрээнд 2 тушаалын төсөл, 2 журмын төслийг эрх зүйн мэргэжилтнүүдтэй хамтран боловсруулж, Ашигт малтмал, газрын тосны газрын 2025 оны 02 дугаар сарын 04-ний өдрийн А/20 тоот тушаалаар “Цацрагийн хэмжилтийн протокол, тэмдэглэлийн загварууд батлагдсан. Мөн цацрагийн хяналтын чиглэлээр хийсэн 10	100%	93%	

							жилийн хяналт шалгалтын нэгдсэн танилцуулга бичиж, хяналтын 3 хуудаст санал боловсруулж, цөмийн болон цацрагийн хяналт шалгалтыг хийхэд тулгарч буй хуулийн заалтуудын талаар албан бичиг боловсруулан АҮЭБЯ-д 1/47, 1/619 тоот албан бичгээр хүргүүлэн ажилласан.		
4.1.1	Цөмийн энергийн салбар болон хяналт шалгалттай холбоотой холбогдох дүрэм, журам, шийдвэрийн төсөлд санал өгч ажиллах	Үйл ажиллагааны зардлаар	Нийт хүргүүлсэн саналаас Хууль журамд нийцүүлэн хүргүүлсэн саналын эзлэх хувиар	-	-	100	Газрын даргын 2025 оны 01 дүгээр сарын 02-ны өдрийн “Ажлын хэсэг байгуулах” тушаалын хүрээнд 2 тушаалын төсөл, 2 журмын төслийг эрх зүйн мэргэжилтнүүдтэй хамтран боловсруулж, Ашигт малтмал, газрын тосны газрын 2025 оны 02 дугаар сарын 04-ний өдрийн А/20 тоот тушаалаар “Цацрагийн хэмжилтийн протокол, тэмдэглэлийн загварууд батлагдсан. Мөн цацрагийн хяналтын чиглэлээр хийсэн 10 жилийн хяналт шалгалтын нэгдсэн танилцуулга бичиж, хяналтын 3 хуудаст санал боловсруулж, цөмийн болон цацрагийн хяналт	100%	90%

							шалгалтыг хийхэд тулгарч буй хуулийн заалтуудын талаар албан бичиг боловсруулан АҮЭБЯ-д 1/47, 1/619 тоот албан бичгээр хүргүүлэн ажилласан.		
4.1.2	Ашигт малтмалын салбарт мөрдөх дүрэм, журам, заавар, аргачилсан зөвлөмжийг боловсруулахад оролцох	Үйл ажиллагааны зардлаар	Нийт хүргүүлсэн саналаас Хууль журамд нийцүүлэн хүргүүлсэн саналын эзлэх хувь.	-	80	100	1.Газрын даргын 2025 оны 01 дүгээр сарын 02-ны өдрийн “Ажлын хэсэг байгуулах” тушаалын хүрээнд салбарын хэмжээнд мөрдөгдөж буй гадагш чиглэсэн дүрэм, журам, зааврын жагсаалтыг гаргаж хууль эрх зүйн хэлтэс, дотоод хяналт шалгалт аудитын газар тус тус хүргүүлсэн. Ажлын хэсгийн төлөвлөгөөний дагуу 2 тушаалын төсөл “Хортой нөхцөлд ажиллах албан хаагчдад олгох нэмэгдэл”, “Цацрагийн хэмжилтийн протокол, тэмдэглэлийн загвар”-ийг мөн “Аж ахуйн нэгж, байгууллагаас ирүүлсэн цацрагийн аюулгүй ажиллагааны дотоод дүрэм, цацрагийн хамгаалалтын хөтөлбөр, түүнийг хэрэгжүүлэх төлөвлөгөө, ослын үед авах арга хэмжээний төлөвлөгөөнд тавигдах шаардлага, хянаж баталгаажуулах журам”,	100%	100%

						<p>“Цацрагийн үүсгүүрийн жилийн эцсийн тайлан мэдээг боловсруулах, илгээх, хүлээн авах журам” зэрэг 2 журмын төслийг эрх зүйн мэргэжилтнүүдтэй хамтран тус тус боловсруулж удирдлагад танилцуулан, Ашигт малтмал, газрын тосны газрын 2025 оны 02 дугаар сарын 04-ний өдрийн А/20 тоот Загвар батлах тухай тушаалаар “Цацрагийн хэмжилтийн протокол, тэмдэглэлийн загварууд батлагдсан. 2.Цөмийн энергийн комиссын хуралдааны батлагдсан төлөвлөгөө дагуу Цөмийн болон цацрагийн хяналтын чиглэлээр орох материалыг бэлтгэн, цацрагийн хяналтын чиглэлээр хийсэн 10 жилийн хяналт шалгалтын мэдээг нэгтгэн танилцуулга бэлтгэж, АҮЭБЯ-ны Салбарын хяналтын газарт цахимаар хүргүүлсэн. 3.Рентген оношилгооны цацрагийн аюулгүй ажиллагааг шалгах хуудас, Цөмийн онош зүйн цацрагийн аюулгүй ажиллагааг шалгах хуудас, Туяа</p>	
--	--	--	--	--	--	--	--

							эмчилгээний цацрагийн аюулгүй ажиллагааг шалгах хуудсуудад хууль тогтоомж, дүрэм журам, стандартад нийцүүлэн өөрчлөлт оруулах холбогдох саналыг боловсруулан Аж үйлдвэр, эрдэс баялагийн яамны Салбарын хяналтын газарт 1/619 тоот албан бичгээр хүргүүлсэн.		
4.2.	Цацрагтай холбоотой үйл ажиллагаа явуулж буй байгууллагуудаас ирүүлсэн цацрагийн үүсгүүрийн тооллогын дүн, дотоод хяналтын тайлан, мэдээнд үнэлгээ хийх	Үйл ажиллагааны зардлаар	Тайлан ирүүлсэн аж ахуйн нэгжийн тоо /өссөн дүнгээр/	219	250		Цацрагтай холбоотой үйл ажиллагаа явуулж буй 281 аж ахуйн нэгж, байгууллагаас ирүүлсэн 2024 оны цацрагийн үүсгүүрийн тооллогын дүн, дотоод хяналтын тайлан, мэдээнд үнэлгээ хийсэн.	100%	90%
4.2.1	Цацрагтай холбоотой үйл ажиллагаа явуулж буй байгууллагуудаас ирүүлсэн цацрагийн үүсгүүрийн тооллогын дүн, дотоод хяналтын тайлан, мэдээнд үнэлгээ хийх	Үйл ажиллагааны зардлаар	Тайлан ирүүлсэн аж ахуйн нэгжийн тоо /өссөн дүнгээр/	219	250	-	Цацрагтай холбоотой үйл ажиллагаа явуулж буй 281 аж ахуйн нэгж, байгууллагаас ирүүлсэн 2024 оны цацрагийн үүсгүүрийн тооллогын дүн, дотоод хяналтын тайлан, мэдээнд үнэлгээ хийсэн	100%	90%
4.3.	Цацрагтай холбоотой үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж байгууллагын цацрагийн аюулгүй ажиллагааны дотоод дүрэм, байгууллагын цацрагийн хамгаалалтын	Үйл ажиллагааны зардлаар	Хүсэлт ирүүлсэн аж ахуйн нэгж байгууллагын дүрэм журам хянасан гүйцэтгэлийн хувь	100	100		Цацрагтай холбоотой үйл ажиллагаа явуулж буй 62 аж ахуйн нэгж байгууллагын цацрагийн аюулгүй ажиллагааны дотоод дүрэм, байгууллагын цацрагийн хамгаалалтын хөтөлбөр төлөвлөгөө, цацрагийн	100%	100%

	хөтөлбөр төлөвлөгөө, цацрагийн ослын үед авах арга хэмжээний төлөвлөгөөг хянах						ослын үед авах арга хэмжээний төлөвлөгөө зэрэг 228 бичиг баримтыг хянан, баталгаажуулалт хийсэн.		
4.3.1	Цацрагтай холбоотой үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж байгууллагын цацрагийн аюулгүй ажиллагааны дотоод дүрэм, байгууллагын цацрагийн хамгаалалтын хөтөлбөр төлөвлөгөө, цацрагийн ослын үед авах арга хэмжээний төлөвлөгөөг хянаж, баталгаажуулах	Үйл ажиллагааны зардлаар	Хүсэлт ирүүлсэн аж ахуйн нэгж байгууллагын дүрэм журам хянасан гүйцэтгэлийн хувь	100	100	100	Цацрагтай холбоотой үйл ажиллагаа явуулж буй 62 аж ахуйн нэгж байгууллагын цацрагийн аюулгүй ажиллагааны дотоод дүрэм, байгууллагын цацрагийн хамгаалалтын хөтөлбөр төлөвлөгөө, цацрагийн ослын үед авах арга хэмжээний төлөвлөгөө зэрэг 228 бичиг баримтыг Цөмийн энергийн тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36.1.4-т заасны дагуу улсын байцаагчид хянаж, баталгаажуулалт хийсэн.	100%	100%
4.4.	Төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран ажиллах, үйл ажиллагааг өргөжүүлнэ	Үйл ажиллагааны зардлаар	Хамтран ажиллах байгууллагын тоо /өссөн дүнгээр/	1	1		Хүн ам, хүрээлэн буй орчныг цацрагийн сөрөг нөлөөлөлд өртөхөөс урьдчилан сэргийлэх, мэдээллийг шуурхай хүргэх, харилцан мэдээлэл солилцох зорилгоор 2025 оны 06 дугаар сарын 03-ны өдөр Байгаль, орчин уур амьсгалын өөрчлөлтийн яамны Цаг уур орчны шинжилгээний газар, Ашигт малтмал газрын	100%	95%

							тосны газар хооронд хамтран ажиллах 2025/ЦУ-14, 2025/107 дугаартай санамж бичгийг байгуулсан. Санамж бичгийн хүрээнд байгаль орчны цацрагийн түвшинд тогтмол хяналт тавих, хяналтыг сайжруулах, мэдээлэл, үр дүнг шуурхай харилцан солилцох, мэргэжил арга зүйн удирдлагаар хангах чиглэлээр хамтран ажиллаж байна.		
4.4.1	Байгаль, орчин уур амьсгалын өөрчлөлтийн яамны Цаг уур орчны шинжилгээний газартай хамтран ажиллах гэрээ байгуулж, хамтын үйл ажиллагааг өргөжүүлэх	Үйл ажиллагааны зардлаар	Хамтран ажиллах байгууллагын тоо	1	1	1	Хүн ам, хүрээлэн буй орчныг цацрагийн сөрөг нөлөөлөлд өртөхөөс урьдчилан сэргийлэх, мэдээллийг шуурхай хүргэх, харилцан мэдээлэл солилцох зорилгоор 2025 оны 06 дугаар сарын 03-ны өдөр Байгаль, орчин уур амьсгалын өөрчлөлтийн яамны Цаг уур орчны шинжилгээний газар, Ашигт малтмал газрын тосны газар хооронд хамтран ажиллах 2025/ЦУ-14, 2025/107 дугаартай санамж бичгийг байгуулсан. Санамж бичгийн хүрээнд байгаль орчны цацрагийн түвшинд тогтмол хяналт тавих, хяналтыг сайжруулах,	100%	100%

							мэдээлэл, үр дүнг шуурхай харилцан солилцох, мэргэжил арга зүйн удирдлагаар хангах чиглэлээр хамтран ажиллаж байна.		
4.4.2	Цаг уур орчны шинжилгээний газраас ирүүлсэн Улаанбаатар хотын хэмжээнд цацрагийн дэвсгэр түвшинд дүн шинжилгээ хийх	Үйл ажиллагааны зардлаар	Хэмжилт хийсэн цэгийн тоо	2	2	2	Тайлант хугацаанд Улаанбаатар хотын 2 цэгт, хөдөө орон нутгийн нийт 35 цэгт өдөр дутам хийгдсэн гамма цацрагийн тунгийн хэмжилтийн дүнг цахимаар хүлээн авч дүн нэгтгэн мэдээллийн сан бүрдүүлэн ажиллаж байна. Гамма цацрагийн тунгийн чадал байгалийн цацрагийн дэвсгэр түвшинд байна.	100%	90%
4.5.	Иргэн, аж ахуйн нэгж байгууллагаас ирүүлсэн өргөдөл, гомдол, албан бичгийг бүрэн шийдвэрлэх	Үйл ажиллагааны зардлаар	Албан бичгийн шийдвэрлэлтийн гүйцэтгэлийн хувь	100	100		Тайлангийн хугацаанд хариутай, хариугүй нийт 669 албан бичиг, 1 өргөдөл хүлээн авч шийдвэрлэсэн ба 174 албан бичгийг боловсруулан 236 аж ахуйн нэгж, байгууллагад хүргүүлсэн. Иргэн Ж.Ундрахаас ирүүлсэн өргөдлийг хүлээн авч, цацрагтай ажиллагчийн мэргэжлийн шарлагын хувийн тунгийн нийлбэр тунг нэгтгэн, 2025 оны 10 дугаар сарын 07-ны өдрийн 06/00-06/043/03 дугаартай улсын	100%	90%

							байцаагчийн дүгнэлт гаргаж хүргүүлсэн.		
4.5.1	Иргэн, аж ахуйн нэгж байгууллагаас ирүүлсэн өргөдөл, гомдол, албан бичгийг бүрэн шийдвэрлэх	Үйл ажиллагааны зардлаар	Албан бичгийн шийдвэрлэлтийн гүйцэтгэлийн хувь	100	100	100	Тайлангийн хугацаанд хариутай, хариугүй нийт 669 албан бичиг, 1 өргөдөл хүлээн авч шийдвэрлэсэн ба 174 албан бичгийг боловсруулан 236 аж ахуйн нэгж, байгууллагад хүргүүлсэн. Иргэн Ж.Ундрахаас ирүүлсэн өргөдлийг хүлээн авч, цацрагтай ажиллагчийн мэргэжлийн шарлагын хувийн тунгийн нийлбэр тунг нэгтгэн, 2025 оны 10 дугаар сарын 07-ны өдрийн 06/00-06/043/03 дугаартай улсын байцаагчийн дүгнэлт гаргаж хүргүүлсэн.	100%	100%
4.5.2	Холбогдох хууль тогтоомжийн хүрээнд иргэн аж ахуйн нэгж, байгууллагын өргөдөл, хүсэлт, гомдол, мэдээлэл, эрх бүхий байгууллагын шийдвэрээр төлөвлөгөөт бус хяналт шалгалт хийх	Үйл ажиллагааны зардлаар	Өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн хувь	-	100	100	Тайлант хугацаанд иргэн аж ахуйн нэгж, байгууллагаас өргөдөл, хүсэлт, гомдол, мэдээлэл, эрх бүхий байгууллагын шийдвэр ирээгүй тул холбогдох хууль тогтоомжийн дагуу төлөвлөгөөт бус хяналт шалгалт хийгдээгүй болно	100%	80%
4.6.	Цөмийн болон цацрагийн аюулгүй байдлын соёлыг хэвшүүлэх	Үйл ажиллагааны зардлаар	Зохион байгуулсан арга хэмжээний тоо	-	1		Шүдний эмнэлгүүдийн цацрагийн аюулгүй байдалд дотоод хяналт тавих ажилтнуудад зориулан “Цацрагийн	100%	100%

							дотоод хяналтын ажилтныг чадавхжуулах нь” сэдэвт сургалт зохион байгуулж, 28 шүдний эмнэлгийн цацрагийн хяналтын ажилтанг хамруулж, цөмийн энергийн салбарын хууль тогтоомж, дүрэм, журам цацрагийн хамгаалалт, аюулгүй байдал, дотоод хяналтын чиглэлээр мэдлэг чадвараа дээшлүүлсэн. Сургалтын оролцогчдоос сургалтын үр дүнгийн талаар 4 асуумжаар сэтгэл ханамжийн судалгаа авч үзэхэд нийт оролцогчдын 92 хувь нь сэтгэл ханамжтай байна гэсэн дүгнэлт өгсөн.		
4.6.1	Шүдний эмнэлгүүдийн цацрагийн аюулгүй байдалд дотоод хяналт тавих ажилтнуудад зориулан “Цацрагийн дотоод хяналтын ажилтныг чадавхжуулах нь” сэдэвт танхимын сургалтыг зохион байгуулах	Үйл ажиллагааны зардлаар	Сургалтад хамрагдсан хүний сэтгэл ханамжийн байдал	-	80	-	Рентген аппарат ашиглан үйл ажиллагаа явуулж буй шүдний эмнэлгүүдэд “Цацрагийн дотоод хяналтын ажилтныг чадавхжуулах нь” сэдэвт сургалтын 2025 оны 11 дүгээр сарын 27-ны өдөр зохион байгуулсан. Тус сургалтад 28 шүдний эмнэлгийн цацрагийн хяналтын ажилтанг хамруулж, цөмийн энергийн салбарын хууль тогтоомж, дүрэм, журам цацрагийн хамгаалалт,	100%	100%

						<p>аюулгүй байдал, дотоод хяналтын чиглэлээр мэдлэг чадвараа дээшлүүлсэн. Оролцогчдыг цацрагийн дотоод хяналтын удирдамж боловсруулах, дотоод хяналтын хуудас боловсруулах, нийтлэг илэрдэг зөрчил дутагдал, түүнд авах арга хэмжээг боловсруулах 3 багт хуваан дасгал ажлыг хийж, үр дүнг танилцуулга хэлбэрээр хэлэлцүүлсэн. Сургалтын оролцогчдоос сургалтын үр дүнгийн талаар 4 асуумжаар сэтгэл ханамжийн судалгаа авч үзэхэд нийт оролцогчдын 92 хувь нь сэтгэл ханамжтай байна гэсэн дүгнэлт өгсөн.</p>		
4.7.	Дээд шатны байгууллагын тушаал, гэрээний холбогдох заалтын хэрэгжилтийг гаргаж, хүргүүлэх	Үйл ажиллагааны зардлаар	Хүргүүлсэн мэдээний тоо	11	11	<p>Үндэсний аюулгүй байдлын зөвлөлд танилцуулах цацрагийн үүсгүүрийн хадгалалт, хамгаалалт аюулгүй байдлын талаарх 2025 оны 01-ээс 11 дүгээр саруудын мэдээг сар бүр гаргаж, АҮЭБЯ-ны Салбарын хяналтын газарт 2024 оны 1/5071, 2025 оны 1/575, 1/1104, 1/1534, 1/2052, 1/2658, 1/3602, 1/4230, 1/5971 дугаартай албан бичгээр</p>	100%	100%

							тус тус хүргүүлэн ажилласан.		
4.7.1	Үндэсний аюулгүй байдлын зөвлөлд танилцуулах цацрагийн үүсгүүрийн хадгалалт, хамгаалалт аюулгүй байдлын талаарх мэдээг сар бүр төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэх	Үйл ажиллагааны зардлаар	Хүргүүлсэн мэдээний тоо	11	6	5	Үндэсний аюулгүй байдлын зөвлөлд танилцуулах цацрагийн үүсгүүрийн хадгалалт, хамгаалалт аюулгүй байдлын талаарх 2025 оны 01-ээс 11 дүгээр саруудын мэдээг сар бүр гаргаж, АҮЭБЯ-ны Салбарын хяналтын газарт 2024 оны 1/5071, 2025 оны 1/575, 1/1104, 1/1534, 1/2052, 1/2658, 1/3602, 1/4230, 1/5971 дугаартай албан бичгээр тус тус хүргүүлэн ажилласан.	100%	100%

Үнэлсэн:

.....

.....

(албан тушаал)

.....

(гарын үсэг)

/...../

.....

(огноо)

Тайлагнасан:

.....

.....

.....

/...../

(албан тушаал)

(гарын үсэг)

.....

(огноо)

Цөмийн болон цацрагийн хяналтын асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн, Алтангэрэл Энхбаатар

2025 ОНЫ ЖИЛИЙН ЭЦЭС-Н ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

НЭГ. ГҮЙЦЭТГЭЛИЙН ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин / биелэлт	Эхэлсэн, дууссан хугаца	Биелэлтийн хувь
	1	2	3	4	5	6	7
1.1. Цөмийн болон цацрагийн хяналтын чиглэлээр их, дунд эрсдэлтэй үнэлэгдсэн 12 аж ахуйн нэгжид төлөвлөгөөт шалгалт хийх							
1	Рентген оношилгооны чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй их, дунд эрсдэлтэй үнэлэгдсэн нийт 12 аж ахуйн нэгж, байгууллагад төлөвлөгөөт хяналт шалгалт хийх	Хууль сахин мөрдөлтийн хувь (өссөн дүнгээр)	75	77	-Төлөвлөгөөт хяналт шалгалтад хамрагдах 12 аж ахуйн нэгж байгууллагад хяналт шалгалт хийх талаар "мэдэгдэх хуудас"-аар мэдэгдсэн. -АҮЭБЯ-ны Цөмийн болон цацрагийн хяналтын салбарын улсын ерөнхий байцаагчийн баталсан 06-00/013 удирдамжийн хүрээнд 12 аж ахуй нэгжид хяналт шалгалт хийж 11 аж ахуй нэгжийг 6.18 кодтой "Рентген оношилгооны цацрагийн аюулгүй ажиллагааг шалгах хяналтын хуудас"-аар , нэг аж ахуй нэгжийг 6.21 кодтой "Цөмийн онош зүйн цацрагийн аюулгүй ажиллагаа шалгах хяналтын хуудас"-аар үнэлэхэд бага 8, дунд 4 аж ахуй нэгж эрсдэлтэй үнэлэгдсэн. Нийт 106 зөрчил илэрүүлсэн. 17	2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100%

				<p>рентген аппаратанд чанарын хяналтын хэмжилт, 236 цэгт ажлын байрны цацрагийн хэмжилт хийсэн. Хяналт шалгалтаар илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулахаар улсын байцаагчийн давхардсан тоогоор 73 заалттай улсын байцаагчийн 06/00-06/046/07, 06/00-06/046/12, 06/00-06/046/13, 06/00-06/046/14, 06/00-06/046/19, 06/00-06/046/20, 06/00-06/046/25, 06/00-06/046/42,06/00-06/046/43, 06/00-06/046/44, 06/00-06/046/48 тоот дугаартай нийт 11 албан шаардлагуудыг хүргүүлж, хугацаатай үүрэг даалгавар өгч ажилласан. Амармед эмнэлгийн цацрагтай холбоотой үйл ажиллагаа нь зогссон байсан. - Б.Мөнхөө улсын байцаагчийн төлөвлөгөөнд орсон 06-00/13 дугаартай удирдамжийн хүрээнд 1 аж ахуй нэгжид хяналт шалгалт хийж 6.18 кодтой “Рентген оношилгооны цагийн аюулгүй ажиллагааг шалгах хяналтын хуудас”-аар үнэлэхэд 33 буюу дунд эрсдэлтэй үнэлэгдсэн. 8 зөрчил илэрүүлсэн. 5 заалттай улсын байцаагчийн албан шаардлага хүргүүлж ажилласан. - Б.Мөнхөө улсын байцаагчийн төлөвлөгөөнд орсон 06-00/12 дугаартай удирдамжийн хүрээнд 1 аж ахуй нэгжид хяналт шалгалт хийж 6.17 кодтой “Цацрагийн үүсгүүрийн аюулгүй ажиллагааг шалгах хяналтын хуудас”-аар</p>		
--	--	--	--	--	--	--

					үнэлэхэд 24 буюу бага эрсдэлтэй үнэлэгдсэн. 6 зөлчил илэрүүлсэн. 5 заалттай улсын байцаагчийн албан шаардлага хүргүүлж ажилласан.		
2	Төлөвлөгөөт хяналт шалгалтад хамрагдсан аж ахуйн нэгж, байгууллагад гүйцэтгэлийн хяналт шалгалт хийх	Гүйцэтгэл хийсэн байгууллагын тоогоор	3	9	АҮЭБЯ-ны Цөмийн болон цацрагийн хяналтын салбарын улсын ерөнхий байцаагчийн баталсан 06-00/013 дугаартай удирдамжуудын дагуу төлөвлөгөөт шалгалт хамрагдсан нийт 11 байгууллагаас 7 байгууллагад гүйцэтгэлийн шалгалт хийсэн. Гүйцэтгэлийн хяналт шалгалт хийсэн 7 аж ахуйн нэгж байгууллагад хугацаатай өгсөн улсын байцаагчийн 40 заалттай албан шаардлагаас 32 заалт бүрэн биелж, албан шаардлагын биелэлтийг 80 хувьтай байна. - Б.Мөнхөө Улсын байцаагчийн хяналт шалгалт хийсэн 5 аж ахуйн нэгж байгууллагад гүйцэтгэлийн хяналт шалгалт хийхэд хугацаатай өгсөн улсын байцаагчийн 46 заалттай албан шаардлагаас 32 заалт бүрэн биелж, албан шаардлагын биелэлтийг 76 хувьтай байна.	3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 80% Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 50%
1.2. Цөмийн болон цацрагийн хяналтын чиглэлээр урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийх							
3	Тусгай зөвшөөрөлгүй цацрагийн үүсгүүрийг илрүүлэх урьдчилан сэргийлэх шалгалт хийх	Хяналт шалгалт хийсэн байгууллагын тоогоор	-	3	Сонгинохайрхан дүүргийн эрүүл мэндийн нэгдэлд тусгай зөвшөөрөлгүйгээр ашиглаж, хадгалж байсан 9 ш цацрагийн үүсгүүрийг илрүүлж, 2502000438 дугаартай зөрчлийн хэрэг нээн,	2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 80% Нэгжийн даргын

					зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа явуулан нотлох баримтыг бүрдүүлж 3 000 000 төгрөгийн торгууль оногдуулсан. 3 рентген цацрагийн үүсгүүрийн үйл ажиллагааг зөрчил арилтал түр хугацаагаар битүүмжилж зогсоосон.	сар, 11-р сар	үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 50%
4	Дулааны цахилгаан станц, нам даралтын зуухнаас гарч буй хаягдал үндсэнд цацрагийн эх үүсгүүр байгаа эсэхэд шинжилгээт урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийх	Хяналтанд хамруулсан дээжийн тоогоор	9	10	Урьдчилан сэргийлэх шалгалт хийх 2025 оны 01 дүгээр сарын 24-ны өдрийн 06-00/005 тоот удирдамжийн хүрээнд Дулааны цахилгаан станц 2, 3, 4 болон Амгалан, Сэлбэ дулааны станцуудаас үнсэн сангийн үнс, үнсэн сан орчмын хөр, зуухны үнснээс нийт 19 дээж авч, дээж авах актыг 5-г үйлдэж, дээжүүдэд цацрагийн аюулгүйн үзүүлэлтүүдийг шинжлүүлэхээр СХЗГ-ын ХАБҮЛЛ-ийн Цацрагийн хяналтын лабораторид дээж хүлээлгэн өгсөн тэмдэглэл 2-ийг үйлдэн шилжүүлсэн. Шинжилгээний үр дүнг авч нэгтгэн боловсруулж хяналт шалгалтын танилцуулгыг боловсруулж, хянуулж баталгаажуулан хүргүүлсэн. Хавсралт: 1 файл	3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100%
1.3. Төвлөрсөн усан хангамжийн эх үүсвэр, ундны усанд урьдчилан сэргийлэх шалгалт хийх							
5	Төвлөрсөн усан хангамжийн эх үүсвэр, ундны усанд урьдчилан сэргийлэх шалгалт хийх	Авсан дээжийн тоо	-	14	Урьдчилан сэргийлэх шалгалт хийх 2025 оны 01 дүгээр сарын 27-ны өдрийн 06-00/008 тоот удирдамжийн хүрээнд 1-р улиралд нийслэлийн	2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 100%

					<p>дүүргүүдийн төвлөрсөн усны 9 эх үүсвэрээс 18 дээж авч, дээж авах актыг 9-г үйлдэж, дээжүүдэд цацрагийн аюулгүйн үзүүлэлтүүдийг шинжлүүлэхээр СХЗГ-ын ХАБҮЛЛ-ийн Цацрагийн хяналтын лабораторид дээж хүлээлгэн өгсөн тэмдэглэл 1-ийг үйлдэн шилжүүлсэн. 1-р улиралд авсан усны шинжилгээний дүн гарсан. 2-р улиралд нийслэлийн дүүргүүдийн төвлөрсөн усны 7 эх үүсвэрээс 14 дээж авч, дээж авах актыг 7-г үйлдэж, дээжүүдэд цацрагийн аюулгүйн үзүүлэлтүүдийг шинжлүүлэхээр СХЗГ-ын ХАБҮЛЛ-ийн Цацрагийн хяналтын лабораторид дээж хүлээлгэн өгсөн тэмдэглэл 2-ийг үйлдэн шилжүүлсэн. 3-р улиралд нийслэлийн дүүргүүдийн төвлөрсөн усны 3 эх үүсвэрээс 6 дээж авч, дээж авах актыг 3-г үйлдэж, дээжүүдэд цацрагийн аюулгүйн үзүүлэлтүүдийг шинжлүүлэхээр СХЗГ-ын ХАБҮЛЛ-ийн Цацрагийн хяналтын лабораторид дээж хүлээлгэн өгсөн тэмдэглэл 2-ийг үйлдэн шилжүүлсэн.</p> <p>Хавсралт: 1 файл</p>	сар	Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100%
3.1. Цацрагтай холбоотой үйл ажиллагаа явуулж буй байгууллагуудаас ирүүлсэн цацрагийн үүсгүүрийн тооллогын дүн, дотоод хяналтын тайлан, мэдээнд үнэлгээ хийх							
6	Цацрагтай холбоотой үйл ажиллагаа явуулж буй байгууллагуудаас ирүүлсэн цацрагийн үүсгүүрийн	Тайланд үнэлгээ хийсэн аж ахуйн нэгжийн тоо	47	-	Хэлтсийн хэмжээнд цацрагтай холбоотой үйл ажиллагаа явуулж буй 141 аж ахуйн нэгж байгууллагын 2024 оны	1-р сар, 2-р сар	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын

<p>тооллогын дүн, дотоод хяналтын тайлан, мэдээнд үнэлгээ хийх</p>			<p>цацрагийн үүсгүүрийн тооллогын дүн, дотоод хяналтын тайлан, мэдээ ирүүлсэн. Үүнээс 63 аж ахуй нэгж байгууллагын жилийн эцсийн тайлан(Google Form)-д 8 агуулгын хүрээнд үнэлгээ хийсэн.Дүгнэхэд 1.Тайлан ирүүлсэн байгууллагын үйл ажиллагааны чиглэлээр шүдний эмнэлэг 80,9%, рентген оношилгооний эмнэлэг 19.1%-тай ирүүлсэн. 2.Тухайн байгууллагын цацрагийн хамгаалалтыг хэрэгжүүлэх төлөвлөгөөний биелэлт хангалттай биелүүлсэн 47.6%, хангалтгүй-36.5%, тайланд тусгаагүй 15.9%-тай байна. 3.Цацрагтай ажиллагчдын хөдөлмөрийн нөхцөлийн сайжруулах талаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээ нь нөхцөл сайжирсан 50.7%, тайланд тусгаагүй 26.9%, сайжраагүй 22.4%-тай байна. 4.Мэргэжлийн шарлагын хувийн тунгийн хяналтад 100% хамрагдсан. 5.Мэргэжлээс шалтгаалах өвчний эмнэлгийн үзлэгт 65.1% хамрагдсан. 6.Цацрагийн хэмжилтийн багажтай-15.8%, бусад байгууллагаар хэмжилт хийлгэдэг-49.2%, бусад нь багажгүй байна. 7.Ашиглаж байгаа болон ашиглахгүй байгаа цацрагийн үүсгүүрийн дэлгэрэнгүй судалгааг үйл ажиллагааны төрлөөр ангилсан.</p>	<p>үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100%</p>
--	--	--	---	---

					8.Үр дүн, тулгамдаж буй асуудлаар санал авсан болно.		
3.2. Салбарын чиглэлээр мөрдөгдөж буй хууль бусад хууль тогтоомжийн төсөлд санал өгөх, төслийн хувилбар боловсруулна							
7	Цөмийн энергийн салбар болон хяналт шалгалттай холбоотой холбогдох дүрэм, журам, шийдвэрийн төсөлд санал өгч ажиллах	Нийт хүргүүлсэн саналаас Хууль журамд нийцүүлэн хүргүүлсэн саналын эзлэх хувь.	-	100	Аж Үйлдвэр, Эрдэс Баялагийн яамнаас ирүүлсэн хүсэлтийн дагуу "Туяа эмчилгээний цацрагийн аюулгүй ажиллагааг шалгах" хяналтын хуудасанд 11 санал, "Цөмийн онош зүйн цацрагийн аюулгүй ажиллагааг шалгах" хяналтын хуудасанд 11 санал буюу нийт 22 санал боловсруулж өгсөн. Хавсралт: 1 файл	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100%
8	Ашигт малтмалын салбарт мөрдөх дүрэм, журам, заавар, аргачилсан зөвлөмжийг боловсруулахад оролцох	Нийт хүргүүлсэн саналаас Хууль журамд нийцүүлэн хүргүүлсэн саналын эзлэх хувиар	-	100	Цацрагийн хэмжилтийн протокол, тэмдэглэлийн загварыг боловсруулж хуулийн хэлтэст хүргүүлсэн. Загвар батлах тухай Ашигт малтмал, газрын тосны газрын 2025 оны 02 дугаар сарын 04-ний өдрийн А/20 тоот тушаалаар батлагдсан. Хавсралт: 1 файл	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100%
3.3. Цацрагтай холбоотой үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж байгууллагын цацрагийн аюулгүй ажиллагааны дотоод дүрэм, байгууллагын цацрагийн хамгаалалтын хөтөлбөр төлөвлөгөө, цацрагийн ослын үед авах арга хэмжээний төлөвлөгөөг хянаж, баталгаажуулах							
9	Цацрагтай холбоотой үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж байгууллагын цацрагийн аюулгүй ажиллагааны дотоод дүрэм, байгууллагын цацрагийн	Хүсэлт ирүүлсэн аж ахуйн нэгж байгууллагын дүрэм журам хянасан гүйцэтгэлийн хувь	100	100	Цацрагтай холбоотой үйл ажиллагаа явуулж буй нийт 16 аж ахуйн нэгж байгууллагаас ирүүлсэн Цацрагийн аюулгүй ажиллагааны дотоод дүрэм, байгууллагын цацрагийн	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар,	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 100% Нэгжийн даргын

	хамгаалалтын хөтөлбөр төлөвлөгөө, цацрагийн ослын үед авах арга хэмжээний төлөвлөгөөг хянаж, баталгаажуулах				хамгаалалтын хөтөлбөр, түүнийг хэрэгжүүлэх төлөвлөгөө, цацрагийн болзошгүй ослын төлөвлөгөө зэрэг 60 баримт бичгийг Цөмийн энергийн тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36.1.4-т заасны дагуу хянаж, Аж үйлдвэр, эрдэс баялагийн яамны Салбарын хяналтын газрын цөмийн болон цацрагийн хяналтын хэлтсийн даргаар батлуулан албан бичгээр тус тус хүргүүлж ажилласан.	10-р сар, 11-р сар, 12-р сар	үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100%
3.4. Байгаль, орчин уур амьсгалын өөрчлөлтийн яамны Цаг уур орчны шинжилгээний газартай хамтран ажиллах гэрээ байгуулж, хамтын үйл ажиллагааг өргөжүүлэх							
10	Байгаль, орчин уур амьсгалын өөрчлөлтийн яамны Цаг уур орчны шинжилгээний газартай хамтран ажиллах гэрээ байгуулах ажилд оролцох	Хамтран ажиллах байгууллагын тоо	1	-	Цаг уур, орчны шинжилгээний газартай хамтран ажиллах гэрээний төслийг боловсруулан Хэлтсийн даргаар хянуулан баталгаажуулахад бэлэн болгосон. Цаг уур, орчны шинжилгээний газрын мэргэжилтэн Эрдэнцэцэгт гэрээний төслийг хүргүүлэн санал авч боловсруулсан Цаг уур, орчны шинжилгээний газартай хамтран ажиллах гэрээг холбогдох газруудын дарга нараар гарын үсэг зуруулж 2025 оны 06 дугаар сарын 03-ны өдөр 2025/ЦУ-14, 2025/107 дугаартай гэрээг баталгаажуулсан.	1-р сар, 2-р сар, 3-р сар	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100%
11	Цаг уур орчны шинжилгээний газраас ирүүлсэн Улаанбаатар хотын хэмжээнд цацрагийн дэвсгэр түвшинд дүн	Хэмжилт хийсэн цэгийн тоо	2	2	1-11 сарын Улаанбаатар хот болон хөдөө орон нутгийн нийт 37 цэгт өдөр дутам хийгдсэн цацрагийн тунгийн хэмжилтийн дүнг авч нэгтгээд байна.	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 100%

	шинжилгээ хийх				Хавсралт: 2 файл	сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100%
3.5. Иргэн, аж ахуйн нэгж байгууллагаас ирүүлсэн өргөдөл, гомдол, албан бичгийг бүрэн шийдвэрлэх							
12	Иргэн, аж ахуйн нэгж байгууллагаас ирүүлсэн өргөдөл, гомдол, албан бичгийг бүрэн шийдвэрлэх	Албан бичгийн шийдвэрлэлтийн гүйцэтгэлийн хувь	100	100	Тайлангийн хугацаанд хариутай, хариугүй нийт 62 албан бичиг хүлээн авч шийдвэрлэсэн ба 29 албан бичгийг боловсруулан 29 аж ахуйн нэгж, байгууллагад хүргүүлсэн.	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100%
13	Холбогдох хууль тогтоомжийн хүрээнд иргэн аж ахуйн нэгж, байгууллагын өргөдөл, хүсэлт, гомдол, мэдээлэл, эрх бүхий байгууллагын шийдвэрээр төлөвлөгөөт бус хяналт шалгалт хийх	Өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн хувь	-	100	Тайлант хугацаанд холбогдох хууль тогтоомжийн хүрээнд иргэн аж ахуйн нэгж, байгууллагын өргөдөл, хүсэлт, гомдол, мэдээлэл, эрх бүхий байгууллагын шийдвэрээр төлөвлөгөөт бус хяналт шалгалт хийгдээгүй. Тайлант хугацаанд иргэн аж ахуйн нэгж, байгууллагаас өргөдөл гомдол ирээгүй болно.	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100%
3.6. Шүдний эмнэлгүүдийн цацрагийн аюулгүй байдалд дотоод хяналт тавих ажилтнуудад зориулан “Цацрагийн дотоод хяналтын ажилтныг чадавхжуулах нь” сэдэвт танхимын сургалтыг зохион байгуулах							
14	Шүдний эмнэлгүүдийн цацрагийн аюулгүй байдалд	Сургалтад хамрагдсан хүний	-	-	Рентген аппарат ашиглан үйл ажиллагаа явуулж буй 30 шүдний	4-р сар, 5-р сар, 6-р сар,	Өөрийн үнэлгээ:

